Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж ахлах аудитор М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянбулаг сумын сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн байна.

Баянбулаг сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Д.Пүрэвсүрэн, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Нямбүрэн нар зурж байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

аянбулаг сум нь “Төрийн үйлчилгээг хүргэх, хүний хөгжлийг хангаж уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлсэн дэд бүтцэд тулгуурлан, зах зээлд өрсөлдөхүйц нутгийн шилдэг бүтээгдэхүүнтэй хангайн бүсийн тэргүүлэх сум болно” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Баянбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн 1,371,114.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,711.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,597.8 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 281,836.5 мянга, эцсийн үлдэгдэл 674,741.2 мянган төгрөг болж 392,904.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө	281,836.5	674,741.2	392,904.7	100.0
Дүн	281,836.5	674,741.2	392,904.7	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 674,741.2 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 378,604.8 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 156,222.9 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 139,913.5 мянган төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 187,402.9 мянга, эцсийн үлдэгдэл 173,431.2 мянган төгрөг болж 13,971.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	1,754.3	-	(1,754.3)
Татаас санхүүжилтын авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	-	15,719.7	15,719.7
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
Хувь хүмүүст олгосон зээл	185,648.6	157,711.4	(27,937.2)
Дүн	187,402.9	173,431.1	(13,971.8)

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 90.9 хувь буюу 157.711.4 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 8.7 хувь буюу 15,107.9 мянган төгрөг ЗДТГ, 611.8 мянган төгрөг нь ИТХ-ын авлага байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	425.20	15,107.90	14,682.70	8.7
ИТХ	1,329.10	611.80	(717.30)	0.4
Бага сургууль	-	-	-	-
ЭМТ	-	-	-	-
СХС	185,648.60	157,711.40	(27,937.20)	90.9
Цэцэрлэг	-	-	-	-
ЕБС	-	-	-	-
ОНХСан	-	-	-	-
НИЙТ ДҮН	187,402.90	173,431.10	(13,971.80)	100.00

Эх сурвалж: Баянбулаг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 185,648.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд зээл 43,000.0 мянган төгрөгийн зээл олгосон бөгөөд 76,852.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 157,711.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 81,852.6 мянга, эцсийн үлдэгдэл 187,754.1 төгрөг болж, 105,902.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	54,023,2	151,044,5	97.021.3
Эм боох материал	00		(00)
Бичиг хэргийн материал	1260,0	1002,7	(257.3)
Аж ахуйн материал	9205,9	8493,4	(712.5)
Сэлбэг хэрэгсэл	310,0	2724,0	2414.0
Түлш, шатах тослох материал	00		(00)
Барилгын засварын материал	00		(00)
Хүнсний материал	00	3200,0	3200
Бусад хангамжийн материал	17,053,0	21,289,5	4236.5
Мал амьтад			0
Нөөцийн бараа			
Дүн	81,852,1	187,754,1	105.902.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 187,754.1 мянган төгрөг болж өмнөх оноос 105,902.0 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-т үнэ төлбөргүй авсан 161,604.0 мянган төгрөгийн Тусгай зориулалтын материал голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	1,936,1	1,936,1	00	1,03
ЗДТГ	79,916,0	185,818,0	105,902,0	98,97
Соёл	0			-
ЭМТ	0			-
Бага сургууль	0	00		0
ЕБС	0			-
Цэцэрлэг	0			-
НИЙТ ДҮН	81,852,1	187,754,1	105,902,0	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 248,422.9 мянган төгрөгийн бараа материалын 86,668.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 161,604.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, 149.6 мянган төгрөгийг шилжүүлэн авсан байна.

Мөн нийт хасагдсан 142,521.0 мянган төгрөгийн 141,801.0 мянган төгрөг буюу 99.0 хувийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	248,422.9	Хасагдсан	142,521.0
Худалдан авсан	86,668.6	Худалдсан, зарцуулсан	141,801.0
Хандиваар	161,604.7	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	
Шилжүүлсэн авсан	149.6	шилжүүлсэн	
бусад		бусад	720.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,568,582.5 мянга, эцсийн үлдэгдэл 1,787,381.1 мянган төгрөг болж 218,798,7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	1,568,582,4	1,787,381,1	218,798,7	100
Барилга байгууламж, орон сууц	800,356,7	820,356,7	20,000,0	9,1
Тээврийн хэрэгсэл	180,114,8	295,704,8	115,590,0	52,8
Машин тоног төхөөрөмж	253,354,1	163,124,5	(90,229,6)	0,41
Тавилга эд хогшил	54,281,1	59,631,1	5,350,0	2,4
Зам гүүрийн байгууламж	0	00	00	00
Түүх соёлын дурсгалт зүйл	0	00	00	0.0
Дуусаагүй барилга байгууламж	00	00	00	0.0
Номын фонд	0	00	00	0.0
Бусад үндсэн хөрөнгө	231,399,5	388,403,8	157,004,3	71,7
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	49,076,2	60,160,2	11,084,0	
Программ хангамж	5,760,0	5,760,0	00	0.0
Бусад биет бус хөрөнгө	43,316,2	54,400,2	11,084,0	0,1
НИЙТ ДҮН	1,568,582,4	1,787,381,1	218,798,7	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 98.5 хувь буюу 215,528.8 мянган төгрөгийг ЗДТГ, 1.5 хувь буюу 3,269.9 мянган төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	14,788,5	18,058,4	3,269,9	1,49
ЗДТГ	1,553,793,9	1,769,322,7	215,528,8	98,51
Соёл				0.0
ЕБС				0.0
Цэцэрлэг				0.0
Эмнэлэг				0.0
Бага сургууль				0.0
НИЙТ ДҮН	1,568,582,5	1,787,381,1	218,798,7	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 316,643,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 81,7 хувь буюу 258,648,2 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	316,643,0	Хасагдсан	97,844,4
Худалдан авсан	57,994,8	Худалдсан	
Хандиваар	0.00	Акталсан	97,844,4
Шилжүүлэн авсан	0,0	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	0
бусад	258,648,2	Бусад	

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,865,5 мянга, эцсийн үлдэгдэл 10,000,0 өглөгийн үлдэгдэлтэй бөгөөд 8,135,5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	1,865,5	10,000,0	8,135,5	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	1,748,7	0	0	00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	0.0		00
Байгууллагад төлөх өглөг	116,8	10,000,0	8,135,5	100
Хувь хүмүүст өгөх өглөг			-	-
Дүн	1,865,5	10,000,0	8,135,5	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөрийн 10,000.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь ЗДТГ дээр байгаа бөгөөд энэ нь халаалтын шугамын засварын ажлын үлдэгдэлийг дутуу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	0	0		
ЗДТГ	1,865,5	10.000,0	100	100
Соёлын төв	0		00	
ЕБС			-	-
ЭМТ				

ОНХС				0
Цэцэрлэг				
СХСан				-
ДҮН	1,865,5	10,000,0	8,134,5	100

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,464,230.1 мянга, эцсийн үлдэгдэл 2,177,979.9 мянган төгрөг болж, 713,749,8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	307,031,8	307,031,8	(0.0)	
Өмч: - төрйн			-	-
Хуримтлагдсан үр дүн	1,141,226,4	1,854,976,2	713,749,8	100
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,971,9	15,971,9	00	00
Дүн	1,464,230.1	2,177,979.9	713,749,8	100

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 713,749.80 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.10 . Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023.07.08-ны өдрийн хуралдаанаар 12/02 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 245,308.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3,000.0 мянга, нийт 248,308.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	245,308.00	654,113.37	408,805.37	266.6
ЦХТА рлого /суутган/	126,280.00	150,052.99	23,772.99	118.8
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	800.00	1,629.23	829.23	203.7
Бууны татвар	4,140.00	2,505.00	-1,635.00	60.5
ИОТХ	9,500.00	9,228.42	-271.58	97.1
Улсын тэмдэгтийн хураамж	7,000.00	11,462.05	4,462.05	163.7
Хадгаламжийн хүүгийн орлого	29,700.00	28,876.19	-823.81	97.2
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.00	400.00	-2,600.00	13.3
Малын тоо толгойн албан татвар	28,000.00	32,881.28	4,881.28	117.4
Газрын төлбөр	1,200.00	1,594.23	394.23	132.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,700.00	12,881.20	7,181.20	226.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	28,288.00	402,102.80	373,814.80	1,421.5
ТТАМАТөлбөр	500.00	500	0.00	100.0
Газрын дуудлага худалдаа	1,200.0	0	-1,200.00	-
2.Татварын бус орлого	3,000.00	5,930.00	2,930.00	197.7

**Баянбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.1.Хүү торгуулийн орлого	3,000.00	5,930.00	2,930.00	197.7
Нийт дүн	248,308.00	660,043.37	411,735.37	265.8

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 265.8 хувь буюу 411,735.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 23,772.9 мянга, Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого 829.2 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,462.1 мянга, газрын төлбөр 394.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 7,181.2 мянга, малын тоо толгойн албан татвар 4,881.3 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 373,814.8 мянга, торгуулийн орлого 2,930.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин бууны албан татвар 1,635.0 мянга, иргэний орлого тодорхойлох татвар 271.6 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 823.8 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 98,367.5 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 76,852.7 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,550,846.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 1,287,157.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас , 1,059,650.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 227,507.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Баянбулаг сумын Засаг дарга			0.00	#DIV/0!
2	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	105,443.0	97,441.2	8,001.84	92.4
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,900.0	1,900.0	0.00	100.0
4	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	464,486.6	455,737.8	8,748.80	98.1
5	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	75,815.4	71,470.7	4,344.70	94.3
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	58,645.3	58,645.3	0.00	100.0
7	80305 Биеийн тамир уралдаан, тэмцээн	3,000.0	2,890.0	110.00	96.3
8	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	32,362.2	32,109.6	252.60	99.2
9	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	84,000.0	79,267.7	4,732.35	94.4
10	82212 хур хог хаягдал, орчны бохирдол	10,700.0	5,507.0	5,192.99	51.5
11	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	20,024.8	17,512.5	2,512.28	87.5
12	71702 Соёл урлаг	70,695.7	62,989.9	7,705.78	89.1
13	71801 Сургуулийн өмнөх боловсрол	40,127.0	39,596.3	530.74	98.7
14	71802 Ерөнхий боловсрол	91,262.7	90,932.2	330.50	99.6
15	70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	75,793.0	71,857.6	3,935.40	94.8
16	83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	216,878.2	98,883.8	117,994.44	45.6
17	73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	6,020.4	6,020.4	0.00	100.0

18	83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	28,000.0	13,360.0	14,640.00	47.7
19	83406 ОНХС -бусад	37,385.4	37,385.4	0.00	100.0
20	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	128,306.6	43,649.9	84,656.70	34.0
	Нийт дүн	1,550,846.30	1,287,157.18	263,689.12	

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.17-ний өдрийн 4/05 дугаар тогтоолоор нийт 1,550,846:3 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	173,586.3	94,059.2	79,527.10
Засаг даргын Тамгын газар	626,478.5	573,150.3	53,328.20
Сургууль	248,405.6	94,496.0	153,909.60
Цэцэрлэг	84,432.2	36,874.0	47,558.18
Эрүүл мэндийн төв	18,564.0	20,024.8	-1,460.80
Соёлын төв	53,441.7	70,695.7	-17,254.00
Сум хөгжүүлэх сан	127,775.6	127,775.6	0.00
Орон нутгийн хөгжлийн сан	301945.7	301,945.7	0.00
Нийт дүн	1,634,629.58	1,319,021.3	315,608.28

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн 10/04 дугаар тогтоолоор анх 1,319,021.3 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.08-ны өдрийн 12/02 дугаар тогтоолоор 231,823.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,550,845.1 мянган төгрөг болжээ.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ	729,008.3	7,056,028.2	-6,327,019.9	967.8941
ИТХ	107,343.0	99,341.2	8,001.8	92.54554
Соёлын төв	70,695.7	62,989.9	7,705.8	89.10007
Сум хөгжүүлэх сан	128,306.6	43,649.9	84,656.7	34.02
Сургууль	91,262.7	90,932.2	330.5	99.63786
Цэцэрлэг	40,127.0	39,596.3	530.7	98.67734
ЭМТ	20,024.8	17,512.5	2,512.3	87.45416
ОНХС	364,077.0	227,507.2	136,569.8	62.48875
Нийт дүн	1,550,845.1	7,637,557.3	-6,086,712.2	1,531.82

Эх сурвалж: Баянбулаг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 7,623.3 мянга, Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 46,634.5 мянган төгрөг орж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 38,538.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,300.0	52,956.7	54,257.8
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0	6323.3	7,623.3
ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0	0
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		46,634.5	46,634.5
НИЙТ ЗАРЛАГА	1,300.0	52,956.7	54,257.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1300.0	37,237.0	38,538.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	15,719.7	15,719.7
Төсөвт төвлөрүүлсэн	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Баянбулаг сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баянбулаг сумын Засаг дарга нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92,6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Баянбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,550,845.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,287,157.3 мянган төгрөгийг зарцуулж, 83.0 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 248,308.00 мянган төгрөг төвлөрүүлэхээс 660,043.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 265.8 хувь буюу 411,735.37 мянган

төгрөгөөр давж биелсэн боловч 5 нэр төрлийн 6,530.4 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 5 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Баянбулаг сумын Засаг даргын харьяа 1 байгууллагад дүгнэлт гаргаж 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	н		Зөрчилгүй	Хязгаарла лттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс тагталзсан	
ЗДТГ	1	1	1				1				
ИТХурал	1	1			1						
ОНХС	1	1			1						
СХС	1	1			1						
НИЙТ ДҮН	4	4	1		3		1	0	0		0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 166,305.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 143,803.9 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 4,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 18,501.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ХХС	1	18,501.9					1	18,501.9		
ОНХСан	1	132,719.9	1	132,719.9						
ЗДТГ	2	15,084.0	1	11,084.0	1	4,000.0				
СТА зөрчлийн дүн	4	166,305.8	2	143,803.9	1	4,000.0	1	18,501.9		
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ										
НХСан										
Нийцлийн аудитын дүн										
Нийт дүн	4	166,305.8	2	143,803.9	1	4,000.0	1	18,501.9		

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	12		
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	60		
5	Тухай бүр	6	72	72		
	Нийт	28	155	155		

Эх сурвалж.Баянбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баянбулаг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илрээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6 алдаа, зөрчил илэрснээс 6 төлбөрийн акт алдаа, зөрчил давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын 21-ний өдрийн 100 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	5	38,629.3	5	38,629.3			100.0
Хариуцлага тооцох	1	0	1	0			100.0
Нийт	6	38,629.3	6	38,629.3			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1 зөрчил илэрэх зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ

Илрүүлэлт: Баянбулаг сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 166,305.8 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн харьяанд нэгтгэгддэг төсвийн шууд захирагчдын Нягтлан бодох бүртгэлийн тайлагнал, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:	
			БНА-2024/3/НА-СТА-ТТЗ	
2023				
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянбулаг сумын Засаг дарга	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
	ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:				
1	Баянбулаг сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 166,305.8 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн байна.	0	Зөвлөмж өгөв.	Төсвийн захирагч, Санхүүгийн албан дарга	Г.Доржбат, Б.Анхбаяр
ДҮН		0			

_____оОо_____